| <b>2104</b>                                        | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                                                                                                 | <b>6,960,000.00</b>   |
| 210402                                             | Тээвэр, шатахуун                                                                                                                                        | 6,960,000.00          |
| <b>2106</b>                                        | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                                                                                                 | <b>3,500,000.00</b>   |
| 210601                                             | Багаж техник хэрэгсэл                                                                                                                                   | 3,500,000.00          |
| <b>2108</b>                                        | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж</b>                                                                                          | <b>79,253,800.00</b>  |
| 210801                                             | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                                                                    | 79,253,800.00         |
| <b>2109</b>                                        | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                                                                                                  | <b>17,860,000.00</b>  |
| 210901                                             | Бараа үйлчилгээний бусад зардал                                                                                                                         | 17,860,000.00         |
| <b>213</b>                                         | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                                                                                                 | <b>6,400,000.00</b>   |
| <b>213305</b>                                      | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                                                                                                           | <b>6,400,000.00</b>   |
| 213305                                             | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                                                                                                   | 6,400,000.00          |
| <b>13</b>                                          | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                                                                                                   | <b>130,044,800.00</b> |
| <b>1311</b>                                        | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                                                                      | <b>130,044,800.00</b> |
| 131103                                             | ЗГНХ, ЗД-ын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 35,971,000.00         |
| 131104                                             | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө                                              | 94,073,800.00         |
| <b>12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>    |                                                                                                                                                         | -                     |



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймгийн Соёл урлагийн газар нь тайлант онд 1 хөтөлбөр, 2 арга хэмжээг төлөвлөн Төрөөс соёл урлагийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар соёл урлагийн салбарын нийгэм эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилготой байгууллага юм.

Тус байгууллага нь 2023 онд үндэсний түүх, өв соёлын онцлогийг агуулсан, мэдлэг, мэдээлэлд суурилсан бүтээлч аж үйлдвэрийн салбарыг дэвшилтэт техник технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж шинэ чадавх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, улс, бүс нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, Соёлын өвийг хадгалж, хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэх, Соёлын өвийн бүртгэл, хяналт, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах, баяжуулах, өвлүүлэх найдвартай тогтолцоог бэхжүүлэх, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Соёлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Соёл урлагийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,603.1 мянган төгрөгөөр буюу 40.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| /мянган төгрөгөөр/                           |                 |                 |                 |
|----------------------------------------------|-----------------|-----------------|-----------------|
| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт        |
| Б                                            | 1               | 2               | 3=2-1           |
| Авлага                                       | -               | 6,400.0         | 6,400.0         |
| Бараа материал                               | 4,533.3         | 8,598.8         | 4,065.5         |
| Үндсэн хөрөнгө                               | 34,466.8        | 39,604.4        | 5,137.6         |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>39,000.1</b> | <b>54,603.2</b> | <b>15,603.1</b> |
| Өр төлбөр                                    |                 | 6,400.0         | 6,400.0         |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 39,000.1        | 48,203.2        | 9,203.1         |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>39,000.1</b> | <b>54,603.2</b> | <b>15,603.1</b> |

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Музейн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, Соёлын сайдын 2023 оны А/401 тоот тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн музейн үзэл баримтлалд нийцүүлэн үзүүлэлт, дэглэлтийн төлөвлөгөөг боловсруулахад 16,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй үлдэгдлийг авлагаар бүртгэсэн байна.

Тайлант онд бараа материал 4,065.0 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын хэрэгцээнд 38,865.6 мянган төгрөгийн материал бэлтгэсэн, шатахууны урамшуулалд 204.0 мянган төгрөг авч, 34,800.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Мөн төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж 7,733.8 мянга, тавилга 5,000.0 мянга, нийт 12,733.8 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, тайлант онд 7,596.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан байна.

Дээрх төлөвлөгөөг эрдэмтэн, доктор О.Ангарагсүрэнгээр хийлгэхээр хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээнд заасны дагуу урьдчилгаа 60 хувийг төлснөөр үлдэгдэл 6,400.0 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцооны өөрчлөлт нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Соёл урлагийн газар нь 2023 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 295,023.9 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг 100 хувь улсын төсвөөр бүрдүүлэхээр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 49,376.9 мянган төгрөгөөр бууруулан 245,647.0 мянган төгрөгөөр баталжээ.

Тус газар нь 2022 оны 5 дугаар сард шинээр байгуулагдсан бөгөөд байр ашиглалттай холбоотой зардалд 10,500.0 мянга, эд хогшил худалдан авах зардалд 30,055.0 мянга, урсгал зардалд 8,821.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн нь голлон нөлөөлсөн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэх 245,647.0 мянган төгрөгийг 100 хувь улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр төлөвлөсөн санхүүжилтийг 31.9 мянган төгрөгөөр дутуу авч, урсгал үйл ажиллагаанд 227,095.2 мянган төгрөгийг зарцуулж, 18,519.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 227,095.2 мянган төгрөг буюу 92.45 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шитгэлийг 17,452.9 мянга, хангамж бараа материалыг 260.6 мянга, албан томилолтыг 490.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээг 294.5 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллыг 31.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| /мянган төгрөгөөр/ |                                                |            |           |            |         |
|--------------------|------------------------------------------------|------------|-----------|------------|---------|
| Д/д                | Хөтөлбөр, арга хэмжээ                          | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү      | Биелэлт |
| 1                  | 71402 Соёл урлаг                               | 245,647.0  | 227,095.2 | (18,551.8) | 92.45   |
| 1.1                | 80801-Үндсэн үйл ажиллагааны зардал            | 245,268.6  | 226,748.7 | (18,519.9) | 92.45   |
| 1.2                | 80802 Ажил, олгогчоос олгох тэтгэж, урамшуулал | 378.4      | 346.5     | (31.9)     | 91.57   |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр Соёлын яамнаас улсын хэмжээнд зохион байгуулагдсан "Нүүдэлчин Монгол" наадмын хүрээнд тоног төхөөрөмж, шатахуун, соёл урлагийн арга хэмжээнд 92,645.0 мянга, аймгийн ЗДТГ-аас Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 272 дугаар тогтоолоор 37,395.8 мянган төгрөгийг албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын шимтгэлд тус тус зарцуулахаар санхүүжилт авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Мөн хамтран ажиллах гэрээнд заасны дагуу ажлын хөлсний үлдэгдэл 6,400.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Соёл урлагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Сувдмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Соёл урлагийн газар нь 2023 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ. Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 245,647.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,684.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус газар нь тайлант онд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг 17,452.9 мянга, хангамж бараа материалыг 260.6 мянга, албан томилолтыг 490.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээг 294.5 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллыг 31.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 168,499.2 мянган төгрөгийн 12 орлогын гүйлгээг хугацаанд нь мэдээлжээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 310 тоот албан бичгээр ирүүлснийг шалгахад 100 хувь хэрэгжсэн байлаа.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |           | Биелэлт |           |      |
|-----------------|------------------------|-----------|---------|-----------|------|
|                 | Тоо                    | Дүн       | Тоо     | Дүн       | Хувь |
| Төлбөрийн акт   | 1                      | 1,858.9   | 1       | 1,858.9   | 100% |
| Албан шаардлага | 1                      | 19,824.7  | 1       | 19,824.7  | 100% |
| Зөвлөмж         | 1                      | 210,861.1 | 1       | 210,861.1 | 100% |
| Нийт дүн        | 3                      | 232,544.7 | 3       | 232,544.7 |      |

##### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,600.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

Урьдчилж төлсөн 9,600.0 мянган төгрөгийг тайлант үеийн зардлаар бүртгэсэн байсныг санхүүгийн байдлын тайланд урьдчилж төлсөн зардал дансанд бүртгүүлж, санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүнгээс хасаж залруулав.

Мөн аудитаар санхүүгийн тайлан, төсвийн зардал, Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой нийт 3,709.5 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 3 зөвлөмж өглөө.

##### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

##### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

##### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

###### 1.1 Илрүүлэлт:

Тайлант онд нягтлан бодогчид 430.7 мянган төгрөгийн балансын мөнгөн урамшууллыг цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 онд баталсан 190 дүгээр тушаал "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т заасантай тус тус нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 онд баталсан 190 дүгээр тушаал "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг баримталж "батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлын ангиллаас зарцуулах"

**2. НББ-ийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт:

Тус газар нь санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

НББ-ийн бодлогын баримт бичгийг байгууллагын онцлогт тохируулан нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлсэн боловсруулах

**3. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал**

3.1 Илрүүлэлт:

Тайлант онд 3,278.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер худалдан авахдаа цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээнээс худалдаж аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д заасны дагуу цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | Буруу тусган илэрхийлсэн | Үүнээс     |              | Зөвлөмж |
|-------------------|------------|-----------------------------------|--------------------------|------------|--------------|---------|
|                   |            |                                   |                          | Запруулсан | Запруулаагүй |         |

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.



**Да.Соёл урлагийн газар**

**2023 оны 4-р улирлын санхүүгийн тайлангийн  
бодит байдлын тухай мэдэгдэл**

Дарга Хорлоонов овогтой Соёл-Эрдэнэ, Нягтлан бодогч Ганбаяр овогтой Энхжаргал бид манай байгууллагын 2023 оны 12 сарын 31 -ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17,1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээг бодитоор гаргасан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндсэлэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан;
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн;
3. Байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан;
4. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан;
5. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

(Тамга)

|                  |                                                                                     |                 |
|------------------|-------------------------------------------------------------------------------------|-----------------|
| Дарга:           |  | /Х.Соёл-Эрдэнэ/ |
| Нягтлан бодогч:  |  | /Г.Энхжаргал /  |
| Баталгаажуулсан: | _____                                                                               |                 |



2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН  
ТОЛИЛУУЛГА

1. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого

Тайлагнагч байгууллага

Энэхүү Санхүүгийн тайлангаар Соёл, урлагийн газрын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Санхүүгийн тайланг Ерөнхий нягтлан бодогч 2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгон баталгаажуулсан болно.

Толилуулгын суурь

Санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудтай нийцсэн болно. Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийг хэрэглэсэн болно.

Нягтлан бодох бүртгэлийн зарчим

**Орлого хүлээн зөвшөөрөлт**

Санхүүжилтыг авч үзвэл

| Байгууллагын нэр    | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | Байр ашиглалттай холбоотой санхүүжилт | Нэмэлт санхүүжилт | Үндсэн үйл ажиллагааны орлого | Туслах үйл ажиллагааны орлого |
|---------------------|-----------------------------------|---------------------------------------|-------------------|-------------------------------|-------------------------------|
| Соёл урлагийн газар | 245,615,100                       | 0                                     | 130,044,800       | 0                             | 0                             |
| Нийт орлогын дүн    |                                   |                                       |                   | <b>375,659,900</b>            |                               |

Хөтөлбөр зориулалт, гүйцэтгэл

| Зардлын нэр                       | Хөтөлбөр зориулалт |         |                   |
|-----------------------------------|--------------------|---------|-------------------|
|                                   | Улсын төсөв        |         | Нэмэлт санхүүжилт |
|                                   | 80101              | 80802   | 80101             |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 245,268,600        | 346,500 | 130,044,800       |
| Гүйцэтгэл                         | 226,748,693.36     | 346,500 | 123,644,800       |
| Төөвлөрүүлэн шилжүүлэг            | 18,519,906.64      |         | 6,400,000         |

**1. Авлага**

Тайлант хугацаанд Соёлын сайдын А/401 тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөө боловсруулахад 16 сая төгрөгийн санхүүжилт олгосныг ажлын хэсгийн төлөвлөгөө, гэрээнд заасан санхүүжилтийн дагуу урьдчилгаа төлбөрт 60 хувийг олгож үлдэх 40 хувийн төлбөрийг ажил гүйцэтгэсэн дараа гэж заасны дагуу 6,4 сая төгрөгийн авлага нэмэлт санхүүжилтийн дансанд үүссэн. Тухайн ажилд 2024 оны 5 дугаар сард дуусна.



## 2. Өглөг

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 43-р зүйлд заасан зардлын дүнг л өглөгт тооцож, гэрээнд заасан санхүүжилтийн дагуу урьдчилгаа төлбөрт 60 хувийг олгож үлдэх 40 хувийн төлбөрийг ажил гүйцэтгэсэн дараа 6,4 сая төгрөгийн хувь хүнд төлөх өглөг үүссэн.

### 3. Бараа материал

Данс тооцоонд бүрэн тусгасан. Тайлангийн жил шатахууны талон худалдан авахад гэрээнд заасан урамшууллыг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-материал дансанд бүртгэсэн.

#### **4. Үндсэн хөрөнгө**

Актлах, данснаас хассан, маргаантай хөрөнгө байхгүй, байгууллагын батлагдсан төсвийн хүрэн хөрөнгө худалдан авч холбогдох дансанд тусгасан байна.

Баталгаажуулсан:

Дарга

**Х.Соёл-Эрдэнэ**

Илтгэх хуудас бичсэн:

Ахлах нягтлан бодогч

Г. Энхжаргал



**БҮРТГЭЛИЙН ДАНСНЫ ҮЛДЭГДЛИЙН БАТАЛГАА**  
**ДАРХАН УУЛ АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР**  
*/ данс эзэмшигч байгууллагын нэр /*  
**ТӨРИЙН САНГИЙН НЭГДСЭН ДАНС 100190034003 ДАНСАНД**

Манай 100190034003 дугаарын бүртгэлийн дансаар тухайн жилийн орлого,  
зарлагын гүйлгээ, дансны эхний, эцсийн үлдэгдлийг дараах байдлаар баталсан  
болохыг мэдэгдэж байна.

| 2023 оны<br>эхний<br>үлдэгдэл |                  | 2023 оны төсвийн орлого                 |                | 2023 оны<br>зарлага | 2023 оны үлдэгдэл<br>/төвлөрүүлэх<br>шилжүүлэг/ |
|-------------------------------|------------------|-----------------------------------------|----------------|---------------------|-------------------------------------------------|
| 0                             | Санхүүжилт       | Урсгал үйл<br>ажиллагааны<br>санхүүжилт | 245,268,600.00 | 226,748,693.36      | 18,519,906.64                                   |
|                               |                  | Орон нутгаас<br>санхүүжих санхүүжилт    | -              |                     |                                                 |
|                               | Өөрийн<br>орлого | Үндсэн үйл<br>ажиллагааны орлого        | -              |                     |                                                 |
|                               |                  | Туслах үйл<br>ажиллагааны орлого        | -              |                     |                                                 |
| Нийт дүн                      |                  |                                         | 245,268,600.00 | 226,748,693.36      | 18,519,906.64                                   |

Байгууллагын

Дарга: ...../Х. Соёл-Эрдэнэ/

Тамга / тэмдэг/

Ерөнхий /ахлах  
нягтлан бодогч ...../Г. Энхжаргал/

Үлдэгдлийн баталгааг шалгасан: Төрийн сангийн мэргэжилтний  
тэмдэглэл

Тэмдэг

Гарын үсэг ..... 20 оны... сарын өдөр



**БҮРТГЭЛИЙН ДАНСНЫ ҮЛДЭГДЛИЙН БАТАЛГАА**  
**ДАРХАН УУЛ АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР**

/данс эзэмшигч байгууллагын нэр/

**ТӨРИЙН САНГИЙН НЭГДСЭН ДАНС 100190034401 ДАНСАНД**

Манай 100190034401 дугаарын бүртгэлийн дансаар тухайн жилийн орлого, зарлагын гүйлгээ, дансны эхний, эцсийн үлдэгдлийг дараах байдлаар баталсан болохыг мэдэгдэж байна.

| 2023 оны<br>эхний<br>үлдэгдэл | 2023 оны орлого                                                                                                                                                            |             | 2023 оны зарлага | 2023 оны үлдэгдэл<br>/төвлөрүүлэх<br>шилжүүлэг/ |
|-------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|------------------|-------------------------------------------------|
| 0                             | Төрийн болон нутгийн өмчит бус<br>этгээдээс авсан хандив, тусламж /эцэг эх,                                                                                                | -           | 123,644,800      |                                                 |
|                               | Төсвийн жилийн явцад УИХ-аас<br>соёрхон баталсан Засгийн газар<br>хоорондын гэрээ болон ОУ-ын<br>байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл                                      | -           |                  |                                                 |
|                               | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө<br>түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц<br>хөрөнгөөс зохих байгууллагын<br>шийдвэрийн дагуу тухай төсвийн<br>захирагчид хуваарилсан хөрөнгө | 35,971,000  |                  | -                                               |
|                               | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт<br>тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн<br>захирагчид хуваарилсан хөрөнгө                                                           | 94,073,800  |                  | 6,400,000                                       |
|                               | Төсвийн байгууллагын үндсэн үйл<br>ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт<br>орлого                                                                                         | -           |                  | -                                               |
|                               | Орон нутгийн хөгжлийн сангаас<br>санхүүжих                                                                                                                                 | -           |                  |                                                 |
|                               | Нийт дүн                                                                                                                                                                   | 130,044,800 | 123,644,800      | 6,400,000                                       |

Байгууллагын

Дарга: ...../Х. Соёл-Эрдэнэ/

Тамга / тэмдэг/

Ерөнхий /ахлах/  
нягтлан бодогч ...../Г. Энхжаргал/

Үлдэгдлийн баталгааг шалгасан: Төрийн сангийн мэргэжилтний  
тэмдэглэл

Тэмдэг

Гарын үсэг ..... 20 оны... сарын өдөр

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭМЭЛТ ТӨСВИЙН ТАЙЛАН

Төсвийн өрөнхийлөн захирагч: Соёлын яам  
Төсвийн байгууллага: Дархан-Уул аймгийн Соёл урлагийн газар  
Нэмэлт төсвийн дансны дугаар: 100190034401

2023 оны 12-р сарын 31-ны өдөр  
/төгрөгөөр/

| №  | Санхүүжилт өгсөн байгууллага, төслийн нэр / Төсвийн байгууллагын нэр                                                                                                                                                                                                | Эхний үлдэгдэл | Санхүүжсэн эх үүсвэр                                              |                                                                                                              |                                                                                                                                                               |                                                                                                            |                                                                              |                                               | Зарцуулалт            | Эцсийн үлдэгдэл       | Татан төвлөрүүлсэн  |          |
|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|-------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------|-----------------------|-----------------------|---------------------|----------|
|    |                                                                                                                                                                                                                                                                     |                | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгэдээс авсан хандив тусламж | Төсвийн жилийн өмч УИХ-с соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУ-н байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | ЗГ-нх, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | Дээд шатны төсвийн захирагчид төсвөөс тусгагдсан төсвөөс дээд шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүсээнд бий болсон нэмэлт орлого | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | Нийт санхүүжилт       |                       |                     |          |
| 1  | ДУА-н Засаг даргын захирамж 01-А/151, Цэцэг Дархан төсөл                                                                                                                                                                                                            | 0              |                                                                   |                                                                                                              |                                                                                                                                                               | 3,500,000.00                                                                                               |                                                                              | 7                                             | 8=2+3+4+5+6+7         | 10=1+8-9              | 11                  | 12       |
| 2  | Соёлын сайдын тушаал А/257, Нүүдэлчин соёлын Фестивальд оролцуулахад шаардагдах зардалын санхүүжилт                                                                                                                                                                 | 0              |                                                                   |                                                                                                              |                                                                                                                                                               | 10,000,000.00                                                                                              |                                                                              |                                               | 3,500,000.00          | 3,500,000.00          | -                   | -        |
| 3  | ДУА-н ЗДТГ газар Орон нутгийн нэмэгдэл 2023-07 сар                                                                                                                                                                                                                  | 0              |                                                                   |                                                                                                              | 1,650,000.00                                                                                                                                                  |                                                                                                            |                                                                              |                                               | 10,000,000.00         | 10,000,000.00         | -                   | -        |
| 4  | МУЗГ-н хэрэгжүүлэгч ангилал СҮГД-н тушаал А/24                                                                                                                                                                                                                      | 0              |                                                                   |                                                                                                              |                                                                                                                                                               | 12,800,000.00                                                                                              |                                                                              |                                               | 1,650,000.00          | 1,650,000.00          | -                   | -        |
| 5  | ДУА-н ЗДТГ газар тушаал №02-А/98 Нүүдэлчин соёлын фестивалд оролцох санхүүжилт                                                                                                                                                                                      | 0              |                                                                   |                                                                                                              | 28,000,000.00                                                                                                                                                 |                                                                                                            |                                                                              |                                               | 12,800,000.00         | 12,800,000.00         | -                   | -        |
| 6  | ДУА-н ЗДТГ газар Орон нутгийн нэмэгдэл 2023-08 сар                                                                                                                                                                                                                  | 0              |                                                                   |                                                                                                              |                                                                                                                                                               |                                                                                                            |                                                                              |                                               | 28,000,000.00         | 28,000,000.00         | -                   | -        |
| 7  | ДУА-н ЗДТГ газар Орон нутгийн нэмэгдэл 2023-09 сар                                                                                                                                                                                                                  | 0              |                                                                   |                                                                                                              | 2,312,000.00                                                                                                                                                  |                                                                                                            |                                                                              |                                               | 2,312,000.00          | 2,312,000.00          | -                   | -        |
| 8  | ДУА-н ЗДТГ газар тушаал №02-А/122 Соёлын саялалт-2023 аяны үйл ажиллагааны зардал                                                                                                                                                                                   | 0              |                                                                   |                                                                                                              |                                                                                                                                                               | 5,433,800.00                                                                                               |                                                                              |                                               | 2,700,000.00          | 2,700,000.00          | -                   | -        |
| 9  | ДУА-н ЗДТГ газар тушаал №02-А/134 Дархан хотын өдрийн үйл ажиллагааны зардал                                                                                                                                                                                        | 0              |                                                                   |                                                                                                              |                                                                                                                                                               |                                                                                                            |                                                                              |                                               | 5,433,800.00          | 5,433,800.00          | -                   | -        |
